



**2024 ОНЫ I УЛИРЛЫН ҮНЭТ ЦААСНЫ
АРИЛЖААНЫ ТАЙЛАН**

2024 ОН

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА I УЛИРАЛД


1. Үнэт цаасны арилжаа

2024 оны I улиралд нийт 62 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 124 ХК-ийн 127.55 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 555.57 сая ширхэг хувьцааг, Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 16.72 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 167.35 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг, Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.16 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.70 сая ширхэг нэгж эрхийг, Компанийн өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 42.56 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 447.83 мянган ширхэг өрийн хэрэгслийг тус тус арилжиж, нийт 188.01 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийсэн байна.

Нийт арилжааны үнийн дүнгийн 67.84 хувь буюу 127.55 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 8.90 хувь буюу 16.72 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны арилжаа, 0.62 хувь буюу 1.16 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 22.64 хувь буюу 42.56 тэрбум төгрөгийг компанийн өрийн хэрэгслийн арилжаа тус тус эзэлж байна.

НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

■ Хувьцаа ■ ХБҮЦ ■ Компанийн өрийн хэрэгсэл ■ ХОС



Тайлант хугацаанд өдөрт дунджаар 3.03 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 9.01 сая ширхэг үнэт цаас арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 дахин өссөн байна.


НИЙТ АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД

ҮНЭТ ЦААС		2023 оны I улирал		2024 оны I улирал	
		ширхэг	үнийн дүн	ширхэг	үнийн дүн
ХУВЬЦАА	Анхдагч	119,157,603.00	11,915,760,300.00	84,000,000.00	8,904,000,000.00
	Хоёрдогч	135,574,952.00	40,624,568,622.19	471,573,258.00	118,652,743,228.08
ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС	Анхдагч	-	-	150,000.00	15,000,000,000.00
	Хоёрдогч	76,530.00	7,264,540,700.00	17,353.00	1,728,385,300.00
КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	Анхдагч	85,000.00	8,500,000,000.00	-	-
	Хоёрдогч	33,651.00	3,376,908,453.10	447,834.00	42,562,623,710.00
ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН	Анхдагч	-	-	-	-
	Хоёрдогч	3,304,932.00	2,461,510,705.13	2,705,092.00	1,165,700,645.84
Нийт		258,232,668.00	74,143,288,780.42	558,893,537.00	188,013,452,883.92

1.1 Хувьцааны зах зээлийн арилжаа


Тайлант хугацаанд нийт 62 удаагийн арилжаагаар 124 ХК-ийн 127.55 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 555.57 сая ширхэг хувьцаа арилжигдсанаас 6.98 хувь буюу 8.90 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 93.02 хувь буюу 118.65 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна.

ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 84.50 хувь буюу 100.26 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа, 15.50 хувь буюу 18.39 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа арилжаа тус тус эзэлж байна.

ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Анхдагч зах зээлийн арилжаа

“Ард кредит ББСБ” ХК нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 428 дугаар тогтоол болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/140 тоот тушаалын дагуу “Ард кредит ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргасан буй нэг бүр нь 106 төгрөгийн үнэтэй, нийт 8,904,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 84,000,000 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 02 дугаар

сарын 15-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийг дуусталх хугацаанд авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Анхдагч зах зээлийн арилжаагаар 9,105,862,160 төгрөгийн үнийн дүн бүхий 85,904,360 ширхэг хувьцааг худалдан авахаар 1,583 захиалга ирүүлсэн бөгөөд үнэт цаасны танилцуулга болон андеррайтерийн компаниас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга болон олон нийтээс ирүүлсэн 500,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хувьцааны захиалгыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 94.6 хувиар хувь тэнцүүлэн хуваарилсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 2/709 албан тоотын дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр эхлүүлсэн.

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 118.65 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 471.57 сая ширхэг хувьцаа арилжсан байна. Нийт 124 ХК-ийн үнэт цаас арилжигдсанаас 58 компанийн үнэт цаасны ханш өсөж, 60 компанийн үнэт цаасны ханш буурч, 6 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна.

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 ХУВЬЦАА

СИМБОЛ	ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ	№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
GOV	ГОВЬ	266,206,759	1	GOV	ГОВЬ	67,890,940,499.24
BOGD	БОГД БАНК	72,240,241	2	KHAN	ХААН БАНК	8,750,246,897.00
GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	41,858,604	3	BOGD	БОГД БАНК	6,120,099,969.63
LEND	ЛЭНДМН БЭСБ	13,537,955	4	GLMT	ГОЛОМТ БАНК	4,701,244,966.78
MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	12,592,839	5	TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	3,226,404,560.00
CUMN	ПРЕМИУМ НЭКСУС	10,274,453	6	XAC	ХАС БАНК	3,108,561,030.60
MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	9,335,608	7	APU	АПУ	2,842,093,632.80
ADB	АРД КРЕДИТ БЭСБ	8,354,193	8	GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	2,701,890,174.44
KHAN	ХААН БАНК	7,762,982	9	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	2,531,161,892.00
MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	4,712,804	10	INV	ИНВЕСКОР БЭСБ	2,503,988,400.00
XAC	ХАС БАНК	4,527,147	11	TTL	ТАВАН ТОЛГОЙ	2,171,255,740.00
GLMT	ГОЛОМТ БАНК	3,538,641	12	MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	1,423,866,892.09
APU	АПУ	2,771,254	13	CUMN	ПРЕМИУМ НЭКСУС	1,281,231,002.55
MFC	МОНОС ХҮНС	1,681,214	14	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	996,380,944.42
MNP	МОНГОЛ ШУУДАН	1,051,589	15	TAS	ЭРДЭНЭТ ХҮНС	971,996,075.00
TUM	ТҮМЭН ШУВУУТ	922,726	16	MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	892,047,311.39
SBM	ТӨРИЙН БАНК	918,930	17	ADB	АРД КРЕДИТ БЭСБ	887,813,316.59
AIC	АРД ДААТГАЛ	844,372	18	MNP	МОНГОЛ ШУУДАН	863,627,065.67
AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	830,783	19	LEND	ЛЭНДМН БЭСБ	852,442,620.96
NEH	ДАРХАН НЭХИЙ	737,308	20	AIC	АРД ДААТГАЛ	598,200,906.47
JTB	ЖЕНКО ТУР БҮРО	699,388	21	CNF	КРИПТО ҮНДЭСТЭН	516,158,840.00
AMT	ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС	616,107	22	TNGR	ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП	510,142,275.00
SEND	СЭНДЛИ БСББ	560,411	23	SBM	ТӨРИЙН БАНК	487,098,852.34
BODI	БОДЬ ДААТГАЛ	521,448	24	TUM	ТҮМЭН ШУВУУТ	307,028,102.18
MBW	МОНГОЛ БАЗАЛЪТ	477,079	25	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	260,721,137.97
RMC	РЕМИКОН	415,973	26	MFC	МОНОС ХҮНС	161,023,270.03
ITLS	АЙТҮҮЛС	414,128	27	EER	АРИГ ГАЛ	95,511,560.00
TAS	ЭРДЭНЭТ ХҮНС	368,582	28	MBW	МОНГОЛ БАЗАЛЪТ	93,996,657.09
INV	ИНВЕСКОР БЭСБ	362,285	29	ATR	АТАР-ӨРГӨӨ	91,731,620.00
QRAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	350,809	30	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	83,240,547.00
ДҮН		469,486,612.00				117,922,146,759.24
НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ			99.56			99.38

ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 30 ХУВЬЦАА

СНМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2023.03.31	2024.03.29	/төг/	/хувь/
HSX	ХИШИГ УУЛ	751	2,064,471	501.00	3,537.00	3,036.00	605.99
ECV	ЭРЭЭНЦАВ	1	9,180	1,400.00	9,180.00	7,780.00	555.71
TVL	ТАВИЛГА	1	11,180	2,412.00	11,180.00	8,768.00	363.52
ONH	ӨНДӨРХААН	57	910,620	2,990.00	12,620.00	9,630.00	322.07
SOH	ЖИДАКС	29,864	17,244,870	165.00	695.00	530.00	321.21
UNS	УЛААНСАН	18	74,970	1,026.00	4,297.00	3,271.00	318.81
HML	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	1,723	1,935,948	400.00	1,440.00	1,040.00	260.00
TTL	ТАВАН ТОЛГОЙ	91,170	2,171,255,740	10,530.00	28,520.00	17,990.00	170.85
SSG	СОНСГОЛОН БАРМАТ	1	2,707	1,100.00	2,707.00	1,607.00	146.09
LEND	ЛЭНДМН ББСБ	13,537,955	852,442,621	31.00	71.04	40.04	129.16
TEX	ТЕХНИК ИМПОРТ	25	955,000	18,100.00	41,440.00	23,340.00	128.95
KEK	МОНГОЛ КЕРАМИК	217	603,268	1,800.00	3,934.00	2,134.00	118.56
NKT	НАКО ТУЛШ	19,131	656,529	24.15	51.00	26.85	111.18
DZG	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	6,220	734,509	82.80	171.00	88.20	106.52
TEE	ТЭЭВЭР ДАРХАН	234	4,037,180	8,260.00	16,840.00	8,580.00	103.87
ABH	АР БАЯНХАНГАЙ	91	70,276	450.00	886.00	436.00	96.89
SHG	ШАРЫН ГОЛ	4,363	3,466,843	560.00	1,100.00	540.00	96.43
MNG	МАНДАЛ ГОВЬ ИМПЭКС	25	38,075	815.00	1,523.00	708.00	86.87
HVL	ХӨВСГӨЛ	3	439	83.63	146.24	62.61	74.87
SDT	ХОТ ДЕВЕЛОПМЕНТ	924	94,218	60.01	102.00	41.99	69.97
UYN	МОНГОЛ САВХИ	2,298	1,922,245	480.00	790.00	310.00	64.58
SOR	СОР	207	157,181	475.00	776.00	301.00	63.37
SIL	СИЛИКАТ	1,310	31,822	17.25	26.97	9.72	56.35
MNH	МОНГОЛ НЭХМЭЛ	238	2,114,000	5,175.00	8,000.00	2,825.00	54.59
HRM	ГЕРМЕС ЦЕНТР	203,948	32,886,569	120.00	173.00	53.00	44.17
BHL	БӨӨНИЙ ХУДАЛДАА	55	31,625	400.00	575.00	175.00	43.75
GFG	СИЛК НЕТ	114	119,579	920.00	1,315.00	395.00	42.93
BTG	БАЯНТЭЭГ	356	9,652,200	21,080.00	30,000.00	8,920.00	42.31
RMC	РЕМИКОН	415,973	17,136,485	32.00	44.93	12.93	40.41
BSKY	БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ	89	155,332	1,180.00	1,588.00	408.00	34.58

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 30 ХУВЬЦАА

СНМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2023.03.31	2024.03.29	/төг/	/хувь/
AMT	ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС	616,107	5,882,813	18.55	8.88	(9.67)	(52.13)
ATR	АТАР-ӨРГӨӨ	2,799	91,731,620	64,200.00	32,000.00	(32,200.00)	(50.16)
MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	107,307	10,194,068	175.13	100.00	(75.13)	(42.90)
HGN	ХӨХГАН	33,753	1,337,814	70.00	40.51	(29.49)	(42.13)
TNGR	ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП	72,415	510,142,275	10,350.00	6,010.00	(4,340.00)	(41.93)
ADL	АДУУН ЧУЛУУН	14,814	7,431,304	801.16	472.00	(329.16)	(41.09)
BEU	БЭРХ УУЛ	1,929	2,668,118	1,983.00	1,189.00	(794.00)	(40.04)
ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	4,032	1,299,812	485.00	304.99	(180.01)	(37.12)
ANH	ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	19,638	40,860,793	3,105.00	2,128.00	(977.00)	(31.47)
TUS	ТҮШИГ УУЛ	1,599	448,520	400.00	280.50	(119.50)	(29.88)
BODI	БОДЬ ДААТГАЛ	521,448	36,927,043	121.00	84.90	(36.10)	(29.83)
BUK	УБ-БУК	23,449	7,569,307	400.00	282.20	(117.80)	(29.45)
BDL	МОГОЙН ГОЛ	106	1,322,900	16,010.00	11,500.00	(4,510.00)	(28.17)
SUU	СҮҮ	180,533	65,591,059	419.73	335.21	(84.52)	(20.14)
DAR	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	54	207,900	4,800.00	3,850.00	(950.00)	(19.79)
DHU	ДАРХАН ХҮНС	369	603,120	2,000.00	1,610.00	(390.00)	(19.50)
MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	2,866	1,308,982	562.00	455.00	(107.00)	(19.04)
BHG	БӨХӨГ	3	3,075	1,260.00	1,025.00	(235.00)	(18.65)
JTB	ЖЕНКО ТУР БҮРО	699,388	22,904,673	47.00	38.31	(8.69)	(18.49)
SEND	СЭНДЛИ БСББ	560,411	77,861,317	160.00	131.62	(28.38)	(17.74)
ITLS	АЙТҮҮЛС	414,128	23,962,085	68.99	56.92	(12.07)	(17.50)
AOI	АВТО ИМПЕКС	196	258,722	1,600.00	1,322.00	(278.00)	(17.38)
MDIC	МОНГОЛ ДААТГАЛ	34	87,900	3,050.00	2,550.00	(500.00)	(16.39)
SBM	ТӨРИЙН БАНК	918,930	487,098,852	671.11	562.29	(108.82)	(16.21)
CUMN	ПРЕМИУМ НЭКСУС	10,274,453	1,281,231,003	169.96	142.55	(27.41)	(16.13)
APU	АПУ	2,771,254	2,842,093,633	1,295.00	1,090.00	(205.00)	(15.83)
MFC	МОНОС ХҮНС	1,681,214	161,023,270	107.27	91.00	(16.27)	(15.17)
MIE	МАТЕРИАЛИМПЕКС	575	4,830,810	10,000.00	8,600.00	(1,400.00)	(14.00)
SUL	ЖУУЛЧИН ДОТИ ФРИЙ	341	21,915,700	65,750.00	56,550.00	(9,200.00)	(13.99)
TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	100,809	3,226,404,560	33,000.00	28,500.00	(4,500.00)	(13.64)

1.2 Хувьцааны багцын арилжаа

Тайлант хугацаанд 18.39 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 72.79 сая ширхэг хувьцааг багцын арилжаагаар арилжсан байна. Энэ нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 15.50 хувийг эзэлж байна.

№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ШИРХЭГ	ҮНИЙН ДҮН
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	270,000.00	810,000,000.00
2	APU	АПУ	1,843,420.00	1,785,155,400.80
3	BOGD	БОГД БАНК	15,971,720.00	1,348,277,180.00
4	CUMN	ПРЕМИУМ НЭКСУС	6,798,077.00	815,769,240.00
5	GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	40,000,000.00	2,609,600,000.00
6	GLMT	ГОЛОМТ БАНК	2,334,631.00	3,600,001,002.00
7	INV	ИНВЕСКОР ББСБ	290,279.00	2,000,727,175.00
8	JGL	ГОВИЙН ӨНДӨР	62,671.00	10,277,417.29
9	MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	4,133,819.00	784,192,937.73
10	MNP	МОНГОЛ ШУУДАН	629,738.00	580,631,030.76
11	TAS	ЭРДЭНЭТ ХҮНС	368,536.00	971,829,432.00
12	TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	95,560.00	3,074,780,000.00
		ДҮН	72,798,451.00	18,391,240,815.58

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд 15.00 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 150.00 мянган ширхэг, хоёрдогч зах зээлд 1.72 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 17.35 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас арилжсан байна.

Анхдагч зах зээл

“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК олон нийтэд үнэт цаас санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 777 тоот тогтоол болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/343 тоот тушаалын дагуу “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК-ийн олон нийтэд санал болгон гаргасан жилийн 18 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэ бүхий 150,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 1/29 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 1 дүгээр сарын 04-ний эхлүүлсэн.

3. Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа

Тайлан хугацаанд "Үндэсний хувьчлалын сан" болон "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.16 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.70 сая ширхэг нэгж эрхийг арилжсан байна. Үүнээс "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн 250.14 сая төгрөгийн үнийн дүн бүхий 212.35 сая ширхэг нэгж эрхийг багцын арилжаагаар арилжсан.

СИМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2023.03.31	2024.03.29	/төг/	/хувь/
ХОС	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	1,478,799	144,330,782	104.33	102.93	(1.40)	(1.34)
MFG	МАНДАЛИРЭЭДҮЙН ӨСӨЛТ	1,226,293	1,021,369,864	840.49	787.76	(52.73)	(6.27)


4. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

Компанийн өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 42.56 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 447.83 мянган ширхэг өрийн хэрэгсэл арилжсан нь үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны 25.94 хувийг эзэлж байна.

5. Зах зээлийн үнэлгээ

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 их наяд 244.93 тэрбум төгрөг буюу 80.34 хувиар өсөж, 11 их наяд 773.10 тэрбум төгрөг болсон байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ




ХАМГИЙН ӨНДӨР ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ 30 КОМПАНИ


СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/
KHAN	ХААН БАНК	2,294,637,600,000.0
TTL	ТАВАН ТОЛГОЙ	1,502,011,504,000.0
TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	1,442,126,419,500.0
APU	АПУ	1,158,642,469,870.0
XAC	ХАС БАНК	747,417,000,000.0
GLMT	ГОЛОМТ БАНК	713,203,397,599.8
INV	ИНВЕСКОР ББСБ	537,784,395,100.0
SBM	ТӨРИЙН БАНК	424,583,070,412.5
МК	МИК ХОЛДИНГ	352,058,440,000.0
ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	317,248,837,575.4
GOV	ГОВЬ	210,388,540,125.0
MDIC	МОНГОЛ ДААТГАЛ	163,537,469,550.0
CUMN	ПРЕМИУМ НЭКСУС	158,836,627,446.7
SUU	СҮҮ	114,997,784,191.9
BOGD	БОГД БАНК	101,825,000,000.0
UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	97,330,574,181.0
AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	85,470,803,581.0
GTL	ГУТАЛ	73,647,467,600.0
MNP	МОНГОЛ ШУУДАН	70,606,731,367.0
TUM	ТҮМЭН ШУВУУТ	68,066,000,000.0
MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	66,904,099,506.2
TEX	ТЕХНИК ИМПОРТ	59,953,527,200.0
MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	58,054,285,235.4
GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	57,689,150,917.1
LEND	ЛЭНДМН ББСБ ХК	52,519,991,560.3
MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	46,822,620,000.0
QPAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	42,339,617,640.0
ADB	АРД КРЕДИТ ББСБ	37,939,720,000.0
MFC	МОНОС ХУНС	37,205,388,948.0
BUK	УБ-БҮК	37,122,704,500.0
ДҮН		11,130,971,237,607.2
Нийтэд эзлэх хувь		94.90

6. ИНДЕКС

Тайлант хугацаанд TOP-20 индексийн дээд үзүүлэлт 45 024.07 нэгж, доод үзүүлэлт 40 704.45 нэгж, дундаж үзүүлэлт 42 988.31 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 969.81 нэгжээр буюу 21.70 хувиар өсөж, 44 693.58 нэгж болсон байна.



Тайлант хугацаанд MSE-A индексийн дээд үзүүлэлт 18 195.59 нэгж, доод үзүүлэлт 16 725.34 нэгж, дундаж үзүүлэлт 17 397.53 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 629.23 нэгжээр буюу 17.33 хувиар өсөж, 17 799.40 нэгж болсон байна.



Тайлант хугацаанд MSE-B индексийн дээд үзүүлэлт 12 731.21 нэгж, доод үзүүлэлт 11 321.67 нэгж, дундаж үзүүлэлт 12 079.01 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 270.77 нэгжээр буюу 2.17 хувиар буурч, 12 207.55 нэгж болсон байна.

